

ДАЙЧИЛГААНЫ ЗАРЛАН МЭДЭЭЛЭЛ ЯВУУЛАХ ЖУРМЫГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Дайчилгааны тухай хуулийн 7.2, 18 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 462 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн дайчилгаа удирдах бүлэг, Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлэх, дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулахад оногдуулан данслагдсан хүн, техникийг дайчилгааны даалгаврын дагуу тогтоосон хугацаанд нь татан нийлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах, холбоо, зарлан мэдээллийн найдвартай ажиллагааг хангах, томилгоот бүрэлдэхүүнд дадлага эзэмшүүлэх зорилгоор зарлан мэдээлэл явуулах журмыг баталсугай.

2. Зарлан мэдээллийн дадлагын дохиог аймгийн Засаг даргын Тамгын газрын цэргийн штаб, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн 2 дугаар холбоочид, дайчилгаа удирдах бүлгийн гишүүд, цугларах болон техник шилжүүлэх байр, сумдын Засаг дарга нарт зарлан мэдээлэл дамжуулж, холбогдох албан тушаалтнууд дохио хүлээн авмагц хариу дохиог аймгийн Засаг даргын Тамгын газар /дохио өгсөн албан тушаалтан/-т мэдэгдэхийг үүрэг болгосугай.

3. Дайчилгаа удирдах бүлгийн гишүүд, цугларах болон шилжүүлэх байр, сум, багын Засаг дарга нар, холбогдох албан тушаалтнуудыг мэргэжлийн арга зүйгээр хангаж, дараагийн үүрэг гүйцэтгэхэд бэлэн байлгахыг ЗДТГ-ын Цэргийн штаб /дэд хурандаа Н.Сүхбаатар/-т даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2008 оны 18 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АЗЖАРГАЛ

ДАЙЧИЛГААНЫ ЗАРЛАН МЭДЭЭЛЭЛ ЯВУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмаар төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд дайчилгааны зарлан мэдээлэл (цаашид “зарлан мэдээлэл” гэх)-ийг шуурхай хүргэх болон уг үйл ажиллагаанд баримтлах дэг, горимыг тогтоохтой холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Энэ журмыг төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэн бүр дагаж мөрдөнө.

1.3. Зарлан мэдээлэл нь бүх нийтийн, хэсэгчилсэн болон сургуулийн гэсэн төрөлтэй бөгөөд зарлан мэдээллийг нууцаар эсхүл илээр явуулна.

1.4. Сургуулийн зарлан мэдээллийг зарлан мэдээллийн тогтолцооны бэлэн байдлыг шалгах, дайчилгааны сургалт дадлагыг зохион байгуулах зорилгоор явуулна.

1.5. Тайван цагт улсын хэмжээнд дайчилгааны зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, бэлэн байдлыг хангана.

1.6. Дайчилгааны зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоо нь дараахь бүрэлдэхүүнтэй байна:

1.6.1. Төрийн захиргааны төв байгууллага түүний харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн зарлан мэдээллийн сүлжээ, техник хэрэгсэл, зарлан мэдээлэл явуулах арга бүхий төрийн захиргааны зарлан мэдээллийн тогтолцоо;

1.6.2. Төрийн цэргийн байгууллага, түүний харьяа цэргийн нэгтгэл, анги, байгууллагын зарлан мэдээллийн сүлжээ, техник хэрэгсэл, зарлан мэдээлэл явуулах арга бүхий төрийн цэргийн зарлан мэдээллийн тогтолцоо;

1.6.3. Бүх шатны орон нутгийн удирдлагын байгууллага, түүний харьяа байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд зарлан мэдээлэл хүргэх мэдээллийн сүлжээ, техник хэрэгсэл, зарлан мэдээлэл явуулах арга бүхий орон нутгийн зарлан мэдээллийн тогтолцоо.

1.7. Дайчилгааны орон нутгийн зарлан мэдээллийн тогтолцоог орон нутгийн хамгаалалтын зарлан мэдээллийг явуулахад ашиглана.

Хоёр. Зарлан мэдээлэл явуулах бэлтгэлийг хангах

2.1. Зарлан мэдээлэл явуулах үүрэг хүлээсэн дайчилгааны даалгавартай төрийн захиргааны төв, төрийн цэргийн болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага нь зарлан мэдээллийн тогтолцоог бүрдүүлж, дараахь бэлтгэлийг хангана:

2.1.1. Зарлан мэдээллийн сүлжээ, томилгоот бүрэлдэхүүн, техник хэрэгсэлд улирал бүр тодотгол хийх;

2.1.2. Зарлан мэдээлэлд ашиглах сүлжээ, техник хэрэгслийн бүрэн бүтэн байдал, найдвартай ажиллагааг хангаж, зарлан мэдээлэл явуулах албан тушаалтан, бие бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах;

2.1.3. Зарлан мэдээллийн тогтолцооны нууцлалыг хангах;

2.1.4. Зарлан мэдээллийн сүлжээ байгуулах, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангахад шаардагдах зардлыг төсөвт тусгаж, санхүүжүүлэх.

2.2. Төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага нь зарлан мэдээлэл явуулахтай холбоотой дайчилгааны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөндөө тусгаж, хэрэгжилтийг хангана.

2.3. Зарлан мэдээллийн тогтолцоо бүрдүүлэх, бэлэн байдлыг хангахад Зэвсэгт хүчний Жанжин штаб, аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб мэргэжлийн дэмжлэг үзүүлнэ.

2.4. Төрийн захиргааны болон төрийн цэргийн тогтолцооны зарлан мэдээллийн бэлэн байдлыг Зэвсэгт хүчний Жанжин штаб, орон нутгийн тогтолцооны бэлэн байдлыг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга жил бүр бүрэн хэмжээгээр шалгаж, дүн болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналаа батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.5. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцооны бэлэн байдлын нэгдсэн дүн, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналыг Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлнэ.

Гурав. Зарлан мэдээлэл явуулах

3.1. Дайчилгаа зарлах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг үндэслэн зарлан мэдээллийг Зэвсэгт хүчний Жанжин штаб дараахь байдлаар зохион байгуулж, явуулна:

3.1.1. Бүх нийтийн зарлан мэдээллийг нийт нутаг дэвсгэрт олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан илээр явуулна;

3.1.2. Хэсэгчилсэн зарлан мэдээллийг дайчилгаа зарласан нутаг дэвсгэрт тогтоосон мэдээллийн сүлжээ ашиглан нууцаар эсхүл илээр явуулна;

3.1.3. Сургуулийн зарлан мэдээллийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, нутаг дэвсгэрт тогтоосон мэдээллийн сүлжээ ашиглан нууцаар явуулна;

3.1.4. Зарлан мэдээллийг илээр явуулах үед олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслийг өргөнөөр ашиглана.

3.2. Зарлан мэдээллийг нууцаар явуулах үед Зэвсэгт хүчний цэргийн нэгтгэл, анги, байгууллага, аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Засаг даргын Тамгын газар нь Зэвсэгт хүчний Жанжин штабаас тогтоосон дохио, захирамжийг хэрэглэнэ.

3.3. Төрийн захиргааны төв болон төрийн цэргийн байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг даргад зарлан мэдээллийг хүргэх ажлыг Зэвсэгт хүчний Жанжин штаб зохион байгуулна.

3.4. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын удирдлага зарлан мэдээлэл хүлээн авсан тухайгаа Зэвсэгт хүчний Жанжин штабын холбогдох албан тушаалтанд мэдэгдэж баталгаажуулна.

3.5. Төрийн захиргааны төв болон төрийн цэргийн байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нар зарлан мэдээллийг эрхэлсэн салбар, харьяалах байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд шуурхай хүргэж, хариу авна.

3.6. Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн зарлан мэдээлэл хүлээн авсан тухайгаа харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтанд мэдэгдэнэ.

Дөрөв. Бусад

4.1. Дайчилгааны зарлан мэдээлэл явуулахтай холбогдох зардлыг зарлан мэдээлэл явуулах үүрэг хүлээсэн төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн төсвөөс санхүүжүүлнэ.

4.2. Энэ журмын хэрэгжилтэд батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

4.3. Энэ журмыг зөрчсөн төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох албан тушаалтан, иргэнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----o0o-----

ДАЙЧИЛГААНЫ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмаар дайчилгаа зарласан тохиолдолд дайчлан татахаар төлөвлөсөн болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэний өмчлөлд байгаа зэвсэг, техник, эд хөрөнгийг бүртгэж, дайчилгааны нөөцийг бүрдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Дайчилгааны нөөцийг бүрдүүлэх зэвсэг, техник, эд хөрөнгийн жагсаалт, тоо хэмжээ нь улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө, төрийн захиргааны төв болон аймаг, нийслэл, сум, дүүргийн дайчилгааны төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг байна.

1.3. Цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага дайчилгааны нөөцийн нэр төрөл, тоо хэмжээ, байршил, нөөцийг бүрдүүлэх болон нөөцтэй байх аж ахуйн нэгж, байгууллагын талаарх саналаа батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

1.4. Дайчилгааны нөөцийн нэр төрөл, тоо хэмжээ, байршил, нөөцийг бүрдүүлэх болон нөөцтэй байх аж ахуйн нэгж, байгууллагыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

Хоёр. Дайчилгааны нөөцийг бүрдүүлэх

2.1. Дайчилгааны нөөц бүрдүүлэх үүрэг хүлээсэн төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн нөөцийг төлөвлөгөөний дагуу бүрдүүлэх, хадгалах, арчлан хамгаалах ажлыг дайчилгааны даалгавар тогтоосон эрх бүхий байгууллага, албан тушаалтны хяналтын дор зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

2.2. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага нь дайчилгааны нөөцийг бүрдүүлэх ажлыг эрхэлсэн салбар, харьяалах аж ахуйн нэгж, байгууллагыг даалгаваржуулах замаар зохион байгуулна.

2.3. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага нь дайчилгааны нөөцийг Засгийн газраас тогтоосон хугацаанд бүрдүүлэх бөгөөд аж ахуйн нэгж, байгууллагатай нөөцөд авах зэвсэг, техник, эд хөрөнгийг үйлдвэрлэж, бэлтгэн нийлүүлэх гэрээ байгуулан хуваарийн дагуу гүйцэтгүүлнэ.

2.4. Дайчилгааны нөөцөд хүлээн авах болон нөөцөөс зарцуулах зэвсэг, техник, эд хөрөнгийн үнийг тухайн үеийн зах зээлийн дундаж ханшаар тооцно.

2.5. Аж ахуйн нэгж, байгууллага нь дайчилгааны нөөцийг тогтоосон хуваарь, хугацааны дагуу бэлтгэн нөөцийн агуулахад хүргэн өгч холбогдох эрх бүхий этгээдэд мэдэгдэнэ.

2.6. Дайчилгааны нөөцөд авах эд хөрөнгө нь дараахь шаардлагыг хангасан байна:

2.6.1. Шинэ байх (зэвсэг, техник, үл хөдлөх хөрөнгөөс бусад эд хөрөнгө);

2.6.2. Нэр төрөл, хэмжих нэгж, тоо хэмжээ, нэг бүрийн үнэ тодорхой байх;

2.6.3. Үйлдвэрлэсэн буюу бэлтгэсэн байгууллагын нэр, он, сар, өдөр, хадгалах хугацааг сав, баглаа боодлын гадна талд тодорхой заасан байх;

2.6.4. Холбогдох стандартын шаардлагыг бүрэн хангасан байх;

2.6.5. Чанарын шинжилгээний дүн, он, сар, өдөр тодорхой байх;

2.6.6. Сав, баглаа боодол нь бүрэн бүтэн байх.

2.7. Дайчилгааны нөөцөд зэвсэг, техник, эд хөрөнгийг шилжүүлэхэд хүлээн авсан, хүлээлгэн өгсөн этгээдийн нэр, байгууллага, албан тушаалыг тодорхой заасан актыг нууцын зэрэгтэйгээр 5 хувь үйлдэж, гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд дор дурдсан байгууллага тус бүр 1 хувийг хадгална:

2.7.1. Дайчилгааны нөөцийг бүрдүүлэх даалгавар өгсөн төрийн захиргааны төв, эсхүл нутгийн захиргааны байгууллага;

2.7.2. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

2.7.3. Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

2.7.4. Эд хөрөнгийг нөөцөд хүлээлгэн өгсөн аж ахуйн нэгж, байгууллага;

2.7.5. Эд хөрөнгийг нөөцөд хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллага.

2.8. Дайчилгааны нөөцөд хүлээн авсан эд хөрөнгөд чанарын шинжилгээ хийснийг нотолсон баримт бичгийг хүлээн авагчийн актад хавсаргасан байна.

2.9. Дайчилгааны нөөцөөс шаардлагатай үед Засгийн газрын шийдвэрээр тодорхой хэмжээгээр зарцуулсан тохиолдолд нөөц бүрдүүлэгч уг зарцуулсан нөөцийг нэр төрөл, тоо хэмжээгээр нь 3 сарын дотор багтаан нөхөн бүрдүүлнэ.

2.10. Цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага дайчилгааны нөөцийн талаар авч хэрэгжүүлсэн ажлын тайланг жил бүр батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.11. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дайчилгааны нөөцийн талаар авч хэрэгжүүлсэн ажлын тайлан болон дайчилгааны даалгавраар тогтоосон дайчилгааны нөөцийн бүрдүүлэлт, хадгалалт, арчлан хамгаалалтад үзлэг, шалгалт явуулсан дүнг Засгийн газарт танилцуулна.

2.12. Дайчилгааны нөөцийн үзлэг, шалгалт, явуулах бүрэлдэхүүн, хугацаа, хамрагдах аж ахуйн нэгж, байгууллагыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

Гурав. Бусад

3.1. Энэ журмын хэрэгжилтэд батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

3.2. Энэ журмыг зөрчсөн, дайчилгааны нөөцөөс дутаасан, нөөцийн чанарыг алдагдуулсан, тогтоосон хугацаанд нөөц бүрдүүлээгүй, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр дайчилгааны нөөцийн нэр төрөл, тоо хэмжээг өөрчилсөн, нөөцтэй холбогдолтой нууц задруулсан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.